

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 09 дүгээр сарын 26

Улаанбаатар хот

Дугаар	Бодлогын үндэслэл	ХБТББ*-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Батлагдсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь	Хүрээгүй бол шалтгаан тайлбар
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Бүлэг. Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах бодлого											
Зорилго. Тээвэр, логистик											
418	НХТЖҮЧ-9.23.1 НЗДҮАХ-6.3.17	Нийтийн тээврийн шинэ төрлийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангана.	Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлыг хангах	2024	ННТГ	-	-	-	Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн дэд бүтцийн судалгааны хүрээлэн болон Far East BRT Planning компанитай “Улаанбаатар хотын нийтийн тээврийн стратеги боловсруулах зөвлөх үйлчилгээ”-ний гэрээ 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан. Зөвлөх үйлчилгээний гэрээ нь 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр хүчин төгөлдөр болж, тусгай нөхцөлийн 13.1-т заасны дагуу 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс зөвлөх үйлчилгээ албан ёсоор эхэлсэн. 2024 оны гуравдугаар улирлын байдлаар зөвлөхийн баг нь Эхлэлийн тайлан болон Дүн шинжилгээний тайланг боловсруулаад байна. Уг тайланг Дэлхийн банк болон оролцогч талууд хянах шатандаа явж байна.	30	

419	АХ-9.3.12 НЗДҮАХ- 6.3.15	Нийтийн тээврийн шинэ төрлийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангана.	Дүүжин замын тээврийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах	20 24	ННТГ	-	-	-	Төслийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2-р шугамын дагуу газар чөлөөлөлт хийх, нарийвчилсан зураг төсөл батлуулах, төсөл хэрэгжиж буй газарт цахилгаан татах, зогсоол, цамхаг, материал, ган татлага хадгалах агуулах бэлтгэх зэрэг нарийвчилсан бэлтгэл ажлуудыг хийхээр ажиллаж байна. Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж нь "Агаарын дүүжин замын тээврийн төсөл"-ийг хариуцан гүйцэтгэж байгаа бөгөөд "Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төсөл"-ийн 2 дугаар шугам болох Наадамчдын өргөн чөлөөг Энхтайваны өргөн чөлөөтэй холбох Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын нэгдсэн цогцолбороос Хархорин автобусны буудал (4.2 км) чиглэлийг төлөвлөн, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг зохион байгуулж байна. Харин шугамын нэгдүгээр трассыг сонгох үүрэг бүхий ажлын хэсэг Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах төслийн нэгж дээр байгуулагдсан ба ахлагчаар Улаанбаатар хотын ерөнхий архитектор Ц.Тулга ажиллаж байна. Дүүжин тээврийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2024 оны гуравдугаар улирлын байдлаар Хан-Уул дүүргийн 23-р хороо, яармагийн эцсийн зогсоолын талбайн газар, шороо, барилга угсралтын ажил хийгдэж байна.	30	
422	НЗДҮАХ- 6.3.14	Нийтийн тээврийн	Нийслэлийн нийтийн	20 24	ННТГ	-	-	-	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар "Тэнүүн-Огоо" ХХК-тай 2023	0	

		үйлчилгээний хүртээмжийг 25 хувиар нэмэгдүүлнэ.	тээврийн хэрэгслийг цахилгаанаар цэнэглэх цэгийг нэмэгдүүлэх						оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн Нийтийн тээврийн автобус худалдан авах ННТГ23001 дугаартай гэрээ, 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Нийтийн тээврийн автобус худалдан авах ННТГ23001-01 дугаартай нэмэлт гэрээг хэсэгчлэн цуцалсантай холбогдуулан уг ажил түр зогсоод байна.		
423	АХ-9.3.1, 9.3.12 НЗДҮАХ- 6.3.14	Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг 25 хувиар нэмэгдүүлнэ.	Нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх	20 24	ННТГ	-	318,000.0	165,589.9	Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон Yutong Bus Co.,Ltd хооронд 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр байгуулагдсан Нийтийн тээврийн автобус нийлүүлэх НЗДТГ/202310014 дугаартай гэрээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн, Нийслэлийн засаг даргын 2024 оны А/15 дугаар захирамжаар дээрх гэрээний дагуу нийлүүлэгдэх их багтаамжийн нийтийн тээврийн автобусыг чанар стандартад нийцүүлэн хүлээн авах ажилд дэмжлэг үзүүлэх, холбогдох заавар зөвлөмжөөр хангах, хяналт тавин ажиллахаар 2024 оны 01 дүгээр сарын 08-аас 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр хүртэл Нийтийн тээврийн газрын 3 албан хаагч, холбогдох албаныхны хамт Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны Эрээн хотод очин захиалагчийн хяналт тавин, хуваарийн дагуу 565 автобус нийт 600 автобусыг Улаанбаатар хот хүртэл тээвэрлэх ажлыг зохион байгуулсан. Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа "Нийтийн тээврийн автобус (Улаанбаатар) төсөл арга	100	

									<p>хэмжээний хүрээнд байгуулагдсан “Нийтийн тээврийн автобус нийлүүлэх гэрээ”, НЗДТГ/202310014-02 дугаартай нэмэлт гэрээ”-нд заасан “Нийтийн тээврийн автобус нийлүүлэх нэмэлт гэрээ”-нд заасан чанар, стандарт, шаардлагад нийцсэн их багтаамжийн 31 автобусыг холбогдох хууль, журмын дагуу хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсгийн “Гадаад томилолтын тухай” 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/1117 дугаар захирамж батлагдсан.</p> <p>Уг захирамжийн хүрээнд Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн “Гадаадад томилолтоор ажиллуулах тухай А/111 дүгээр тушаалын батлагдаж, нийтийн тээврийн зориулалттай их багтаамжийн 31 автобусыг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу шалгаж, хүлээн авахаар ажиллаж байна.</p>		
424	АХ-9.3.1, 9.3.12 НЗДҮАХ- 6.3.14	Нийтийн тээврээр зорчих зорчилтын тоог 20 хувиар нэмэгдүүлнэ.	Нийтийн тээврийн үйлчилгээний хяналт тавьж, орлого төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх	20 24	ННТГ	-	-	-	<p>Нийслэлийн нийтийн тээврийн газрын даргын 2024 оны баталсан “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний хөлс төлөлтийн байдалд хяналт тавих шалгалтын ажлын удирдамж”-ийн дагуу Автотээврийн хяналтын улсын байцаагч болон шалгагч нар хамтран 2024 оны 01 дүгээр сарын 02-наас 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Үзлэг шалгалтаар давхардсан тоогоор нийт 165 чиглэлийн их болон дунд багтаамжийн 1082</p>	70	

									<p>тээврийн хэрэгсэл, 19311 зорчигчийг шалгаж, зорчигчдод соёлтой зөв боловсон үйлчлүүлэх, автобусны чиглэл маршрутын талаар мэдээлэл өгч, зорчигчдын хөлс төлөлтөд хяналт тавьж ажиллалаа. Мөн бэлэн мөнгөөр зорчсон, U money картын үлдэгдэл хүрэлцээгүй, зорчих картгүй, зорчих хөлсөө төлөөгүй зэрэг зөрчил илрүүлж, зөрчлийг газар дээр нь арилгуулж, 5230 зорчигчийг буулгаж, 11,155,600 төгрөгийн посын цэнэглэлт хийж ажиллалаа.</p> <p>2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өссөн дүн, давхардсан тоогоор нийт 2,580 чиглэлийн их болон дунд багтаамжийн 71,351 тээврийн хэрэгсэл, 36,403 зорчигчдыг шалгаж, бэлэн мөнгөөр зорчсон, U money картын үлдэгдэл хүрэлцээгүй, зорчих картгүй, зорчих хөлс төлөөгүй зэрэг нийт 142,498 зөрчил илрүүлж, зөрчлийг газар дээр нь арилгуулж 123,731 зорчигчийг нийтийн тээврийн хэрэгслээр тээвэрлэхээс татгалзан, зорчуулахгүй буулгаж, Easy pay /изи пей/ посын цэнэглэлтээр 2,149,940,000 мянган төгрөгийн цэнэглэлт хийн ажиллаж байна. Нийтийн тээвэр эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын бэлэн мөнгөний орлогыг тус газрын үндсэн үйл ажиллагааны дансанд 2024 оны 05 дугаар сараас эхлэн 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 981,235,525 төгрөгийг төвлөрүүлсэн.</p>		
425	АХ-9.3.1, 9.3.12	Нийтийн тээврээр зорчих	Зорчигч болон замын урсгал туулах	20 24	ННТГ	-	-	-	2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс мөрдөж буй нэгдсэн даалгавраар 131 чиглэлд нийтийн	30	

	НЗДҮАХ-6.3.14	зорчилтын тоог 20 хувиар нэмэгдүүлнэ.	тооцоололд үндэслэн сүлжээ төлөвлөлтийг шинэчилж, шугамын орлого нэмэгдүүлэх менежмент хийх						тээврийн үйлчилгээ ажлын өдөр 06:10-23:30 хооронд 1202, амралтын өдөр 7:20-23:30 цагийн хооронд 955 тээврийн хэрэгслээр үйлчилж байна. Нийтийн тээврийн чиглэлийн дахин төлөвлөлтийн хүрээнд 74 чиглэлийг шинээр нээж иргэдийн саналд тулгуурлан 71 хуучин чиглэлийг сэргээж богино эргэлтийн 34 чиглэлийг хэвээр үлдээсэн. Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд 12 аж ахуйн нэгжийн 32 чиглэлийн өдөрт үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэн, иргэдийн эрэлт хэрэгцээг хангах зорилгоор 5 чиглэлийг шинээр нээж үйлчилгээнд ажиллуулж эхлүүлээд байна. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/110 дугаар захирамжаар 150 тээврийн хэрэгслийн багтаамжтай Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын 3-р баазын үйл ажиллагаа эхэлсэнтэй холбоотойгоор Наадамчдын замаар зорчих тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэн сүл километрийг багасгах үүднээс 6 чиглэлийг шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.		
426	АХ-9.3.1, 9.3.12 НЗДҮАХ-6.3.14	Нийтийн тээврээр зорчих зорчилтын тоог 20 хувиар нэмэгдүүлнэ.	Тээврийн хэрэгслийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагуудыг мөрдүүлж, хяналтыг сайжруулах	20 24	ННТГ	-	-	-	2024 оны гуравдугаар улирлын байдлаар “Зөрчлийн тухай хууль”, “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Автотээврийн тухай” хуулиуд болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журам, “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ, Ангилал ба түүнд тавигдах шаардлага” MNS 5012:2021, “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2020, “Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS	100	

									5122:2013, холбогдох бусад стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор мөн тус газрын даргын баталсан тушаал шийдвэр хэрхэн биелэгдэж байгаад хяналт тавьж, 552 зөрчилд 102 аж ахуйн нэгж, байгууллагад 37,700,000 төгрөг 450 иргэн, албан тушаалтанд 16,530,000 төгрөгөөр нийт 54,230,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллаж байна.		
427	АХ-9.3.1, 9.3.12 НЗДҮАХ- 6.3.14	Нийтийн тээврээр зорчих зорчилтын тоог 20 хувиар нэмэгдүүлнэ.	Нийтийн тээврийн хэрэгслээр тэргэнцэртэй иргэн зорчих нөхцөлийг бүрдүүлэх	20 24	ННТГ	-	-	-	Нийтийн тээврийн үйлчилгээнд 2023 онд шинээр нийлүүлэгдсэн их багтаамжийн евро дизель V хөдөлгүүр бүхий 224 автобус, их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй (Skywell) 35 автобус болон худалдан авахаар төлөвлөгдсөн их багтаамжийн 600 автобусны 100% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нам шалтай, тусгай зориулалтын зорчигчийн хэсэг, бэхэлгээ хийгдсэн бөгөөд дуут зарлан мэдээлэгч, лед дэлгэц, хяналтын камер зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг зорчих боломжийг хангасан тусгай тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон. Улаанбаатар хот хүртэл тээвэрлэх ажлыг зохион байгуулсан. Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа “Нийтийн тээврийн автобус (Улаанбаатар) төсөл арга хэмжээний хүрээнд 2024 оны 09 дүгээр сард нийлүүлэгдэж буй их багтаамжийн 31 автобус нь нам шалтай, тусгай зориулалтын зорчигчийн хэсэг, бэхэлгээ хийгдсэн	100	

									бөгөөд дуут зарлан мэдээлэгч, лед дэлгэц, хяналтын камер зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг зорчих боломжийг хангасан тусгай тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон.		
428	АХ-9.3.1, 9.3.12 НЗДҮАХ- 6.3.14	Нийтийн тээврээр зорчих зорчилтын тоог 20 хувиар нэмэгдүүлнэ.	Нийтийн тээврийн нэгдсэн терминалыг 2 байршилд барих суурь судалгаа, ажлын зураг төслийг боловсруулах	20 24	ННТГ	-	-	-	Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах зураг төсөл боловсруулах тендерт шалгарсан Гео зураглал ХХК-тай 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн ЭЗХЯ/94 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна. Дээрх ажлын хүрээнд Офицеруудын ордон, 120 мянгат орчимд 5 байршилд нийтийн тээврийн терминал байгуулах зураг төслийг гүйцэтгүүлэн авсан. Дээрх ажлын хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Гео зураглал ХХК болон Нийтийн тээврийн газрын холбогдох мэргэжилтнүүд газар чөлөөлөх боломжтой байршлыг судлан газар дээр нь ажилласан бөгөөд тухайн байршлын газар чөлөөлөх ажлыг зохион байгуулах талаар 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 01/02/872 дугаартай албан бичгээр Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн. Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах ажлын хүрээнд сонгогдсон хоёр байршилд ажлын даалгавар гарган өгөх талаарх саналыг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 01/06/1108 дугаартай албан бичгээр Хот байгуулалт, хөгжлийн газарт хүргүүлсэн.	30	
429	АХ-9.3.12 НЗДҮАХ- 6.3.15	Нийтийн тээврийн орон нутгийн өмчит авто	Хан-Уул дүүрэг (Морингийн даваа) 150 нийтийн	20 24	ННТГ	-	-	-	Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Морингийн даваа орчмын 9.8 га газарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийтийн тээврийн авто	90	

		баазын тоог нэмэгдүүлнэ.	тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний авто бааз шинээр барих						бааз барилга угсралтын ажил үргэлжилж байна. Уг бааз нь автобусны дулаан зогсоол, авто угаалга, засварын төв, гадна засварын байгууламж, агуулах, уурын зуух, төрийн үйлчилгээний болон удирдлагын нэгдсэн төвтэй байхаар төлөвлөсөн. Гүйцэтгэгчээр “Улз буянт пропертиз” ХХК ажиллаж байна. Барилгын ажлын явц 90 хувийн гүйцэтгэлтэй цахилгаан хангамжийн ажлын гүйцэтгэл хүлээгдэж байна. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ захиалагчийн хяналт тавьж ажиллаж байна.		
430	АХ-9.3.12 НЗДҮАХ- 6.3.15	Нийтийн тээврийн орон нутгийн өмчит авто баазын тоог нэмэгдүүлнэ.	Сонгинохайрхан дүүрэг (Тахилт) 150 нийтийн тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний авто бааз барих ажлыг үргэлжлүүлэх	20 24	ННТГ	-	-	-	Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороо, Тахилт орчимд 110 нийтийн тээврийн багтаамжтай “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын авто баазын барилга угсралтын ажил үргэлжилж байна. Тус авто баазын барилгын ажлыг 2019 оноос эхлүүлж, 11 аж ахуйн нэгж 13 ажлыг хуваан гүйцэтгэж байна. Эхний ээлжинд 55 автобусны гарашийг барилга угсралтын ажил дуусч комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Энэ онд үлдсэн 55 автобусны гараашны ажлыг дуусгахаар ажиллаж байна. Гараашаас гадна автобус угаалгын төв, засварын төв зэрэг объект барьж байгаа юм. Барилгын ажлын явц 80 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Морингийн даваа болон Тахилт орчимд байгуулж буй автопаркийн объектууд ашиглалтад орсноор ойролцоогоор 200 гаруй автобусыг дулаан гараашинд байрлуулах боломж бүрдэнэ.	90	

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Дугаар	Бодлогын үндэслэл	ХБТББ*-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Батлагдсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь	Хүрээгүй бол шалтгаан тайлбар
1	2	3	4		8	9	10	11	12
Бүлэг. Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах бодлого									
Зорилго. Тээвэр, логистик									
418	НХТЖҮЧ-9.23.1 НЗДҮАХ-6.3.17	Нийтийн тээврийн шинэ төрлийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангана.	Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлыг хангах	Төлөвлөгөө боловсруулах ажлын явц	-	-	Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн дэд бүтцийн судалгааны хүрээлэн болон Far East BRT Planning компанитай “Улаанбаатар хотын нийтийн тээврийн стратеги боловсруулах зөвлөх үйлчилгээ”-ний гэрээ 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан. Зөвлөх үйлчилгээний гэрээ нь 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр хүчин төгөлдөр болж, тусгай нөхцөлийн 13.1-т заасны дагуу 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс зөвлөх үйлчилгээ албан ёсоор эхэлсэн. 2024 оны гуравдугаар улирлын байдлаар зөвлөхийн баг нь Эхлэлийн тайлан болон Дүн шинжилгээний тайланг боловсруулаад байна. Уг тайланг Дэлхийн банк болон оролцогч талууд хянах шатандаа явж байна.	30	

419	АХ-9.3.12 НЗДҮАХ-6.3.15	Нийтийн тээврийн шинэ төрлийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангана.	Дүүжин замын тээврийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах	Бэлтгэл ажлын явц	-	-	Дүүжин тээврийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2024 оны гуравдугаар улирлын байдлаар Хан-Уул дүүргийн 23-р хороо, яармагийн эцсийн зогсоолын талбайн газар, шороо, барилга угсралтын ажил хийгдэж байна.	30	
422	НЗДҮАХ-6.3.14	Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг 25 хувиар нэмэгдүүлнэ.	Нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслийг цахилгаанаар цэнэглэх цэгийг нэмэгдүүлэх	Шинээр байгуулсан цэнэглэх цэг	-	-	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар “Тэнүүн-Огоо” ХХК-тай 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн Нийтийн тээврийн автобус худалдан авах ННТГ23001 дугаартай гэрээ, 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Нийтийн тээврийн автобус худалдан авах ННТГ23001-01 дугаартай нэмэлт гэрээг хэсэгчлэн цуцалсантай холбогдуулан уг ажил түр зогсоод байна.	0	
423	АХ-9.3.1, 9.3.12 НЗДҮАХ-6.3.14	Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг 25 хувиар нэмэгдүүлнэ.	Нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх	1.Шинээр үйлчилгээд нэвтрүүлсэн тээврийн хэрэгсэл	318,000.0	165,589.9	2024 оны гуравдугаар улирлын байдлаар нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд 2023-2024 онд 929 тээврийн хэрэгслээр парк шинэчлэлт хийсэн. Мөн Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа “Нийтийн тээврийн автобус (Улаанбаатар) төсөл арга хэмжээний хүрээнд байгуулагдсан “Нийтийн тээврийн автобус нийлүүлэх гэрээ”, НЗДТГ/202310014-02 дугаартай нэмэлт гэрээ”-нд заасан “Нийтийн тээврийн автобус нийлүүлэх нэмэлт гэрээ”-нд заасан чанар, стандарт, шаардлагад нийцсэн их багтаамжийн 31 автобусыг холбогдох хууль, журмын дагуу хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсгийн “Гадаад томилолтын тухай” 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/1117 дугаар захирамж батлагдсан. Уг захирамжийн хүрээнд Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн “Гадаадад томилолтоор ажиллуулах тухай А/111 дүгээр тушаалын батлагдаж, нийтийн тээврийн зориулалттай их багтаамжийн 31	100	

							автобусыг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу шалгаж, хүлээн авахаар ажиллаж байна.		
				2.Хасагдах тээврийн хэрэгсэл			Хасагдах тээврийн хэрэгсэл 344 байна.		
				3.Өдөрт үйлчилгээнд гарах тээврийн хэрэгсэл			2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс мөрдөж буй нэгдсэн даалгавраар 131 чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээ ажлын өдөр 06:10-23:30 хооронд 1202, амралтын өдөр 7:20-22:30 цагийн хооронд 955 тээврийн хэрэгслээр, шөнийн тээврийн үйлчилгээ 3 чиглэлд 23:00-01:00 хооронд 6 тээврийн хэрэгслээр үйлчилж байна.		
424	АХ-9.3.1, 9.3.12 НЗДУАХ- 6.3.14	Нийтийн тээврээр зорчих зорчилтын тоог хувиар нэмэгдүүлнэ. 20	Нийтийн тээврийн үйлчилгээний хяналт тавьж, орлого төвлөрүүлэлт ийг нэмэгдүүлэх	1.Зорчигчоос бэлнээр мөнгө хураах мөнгөн дэвсгэрт унших, зорчигчийн тоог тоолох давхар үйлдэлтэй төхөөрөмж	-	-	Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд нийлүүлэгдсэн 600 автобусны дотоод камерын системийг удирдлагын нэгдсэн төвд холбох ажлыг хэрэгжүүлж байна. Мөн халаасны хулгайгаас урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлийн Цагдаагийн удирдах газартай хамтран автобусны дотор талын камер хяналтыг хамтран ашиглахаар бэлтгэл ажлыг хангаад байна. Нийтийн тээврийн төлбөрийн менежментийг сайжруулах төслийн хүрээнд Нийтийн тээврийн удирдлагын төвд хяналтын дэлгэц байршуулж, 1006 тээврийн хэрэгсэлд зорчигч тоолох төхөөрөмж суурилуулсан. Бүртгэл мэдээллийн программыг боловсруулж байна.	90	
				2.Нэмэгдүүлэх зорчигч			2024 оны 01 сараас өссөн дүнгээр 82 сая 069 мянган зорчигчдод үйлчилгээ үзүүлээд байна.	90	
425	АХ-9.3.1, 9.3.12 НЗДУАХ- 6.3.14	Нийтийн тээврээр зорчих зорчилтын тоог хувиар нэмэгдүүлнэ. 20	Зорчигч урсгал болон туулах замын тооцоололд үндэслэн сүлжээ төлөвлөлтийг шинэчилж,	Шугамын дундаж орлогын тарифын төрөл	-	-	Зам, Тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/62, А/285 дугаар тушаал, захирамжийн хүрээнд Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг, Хөшигийн хөндийд байрлах Чингис хаан олон улсын нисэх буудал хүртэл нийтийн тээврийн үйлчилгээг хүргэхэд НИТХ-ын 2022 оны 82 дугаар	30	

			шугамын орлого нэмэгдүүлэх менежмент хийх				тогтоол, 2024 оны 21 дүгээр тогтоолуудад зохих өөрчлөлтүүдийг оруулах, эдгээр тогтоолын хэрэгжилтийг хангуулах зорилгоор бэлэн мөнгө хураах, орлого төвлөрүүлэлтийг зохицуулсан журмыг боловсруулан 2024 оны 09 дүгээр 27-ны өдрийн 02/06/2407 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж санал авч байна.		
426	АХ-9.3.1, 9.3.12 НЗДҮАХ- 6.3.14	Нийтийн тээврээр зорчих зорчилтын тоог 20 хувиар нэмэгдүүлнэ.	Тээврийн хэрэгслийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагуудыг мөрдүүлж, хяналтыг сайжруулах	Аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилт	-	-	Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 20 аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийг сар бүр дүгнэдэг бөгөөд хөгжилтийн дундаж 87,2 хувь байна.	100	
427	АХ-9.3.1, 9.3.12 НЗДҮАХ- 6.3.14	Нийтийн тээврээр зорчих зорчилтын тоог 20 хувиар нэмэгдүүлнэ.	Нийтийн тээврийн хэрэгслээр тэргэнцэртэй иргэн зорчих нөхцөлийг бүрдүүлэх	Тавцан төхөөрөмжтэй тээврийн хэрэгсэл	-	-	Нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд 1425 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй үйлчилгээнд ажиллаж байгаагаас 1027 нь буюу 72 хувь нь тавцан төхөөрөмжөөр тоноглогдсон тэргэнцэртэй иргэн үйлчлүүлэх боломжтой тээврийн хэрэгсэл байна.	100	
428	АХ-9.3.1, 9.3.12 НЗДҮАХ- 6.3.14	Нийтийн тээврээр зорчих зорчилтын тоог 20 хувиар нэмэгдүүлнэ.	Нийтийн тээврийн нэгдсэн терминалыг 2 байршилд барих суурь судалгаа, ажлын зураг төслийг боловсруулах	Суурь судалгаа боловсруулах ажлын явц	-	-	Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах зураг төсөл боловсруулах тендерт шалгарсан Гео зураглал ХХК-тай 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн ЭЗХЯ/94 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна.	30	
429	АХ- 9.3.12 НЗДҮАХ- 6.3.15	Нийтийн тээврийн орон нутгийн өмчит авто баазын тоог нэмэгдүүлнэ.	Хан-Уул дүүрэг (Морингийн даваа) 150 нийтийн тээврийн хэрэгслийн	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэнэ.	-	-	Барилгын ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна.	90	

			засвар үйлчилгээний авто бааз шинээр барих						
430	АХ- 9.3.12 НЗДҮАХ- 6.3.15	Нийтийн тээврийн орон нутгийн өмчит авто баазын тоог нэмэгдүүлнэ.	Сонгинохайрх ан дүүрэг (Тахилт) 150 нийтийн тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний авто бааз барих ажлыг үргэлжлүүлэх	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэнэ.	-	-	Барилгын ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна.	90	
								63,64	